



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Иххэт сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/6/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: Цахим хаяг:

Аудитын менежер:

Утас: Цахим хаяг:

Ахлах аудитор: Ц.Лүндэгмаа

Утас: Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	11
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	12
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
2.11.	Шилэн дансны мэдээлэл	14
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	14
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	14
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3	Менежментийн захидал	17
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	19

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.25 № 1-6/354
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.НАМУУНЗУЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Иххэт сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иххэт сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Иххэт сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Иххэт сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн (54 дүгээр зүйлийн 54.3/26 дугаар зүйлийн 26.1)⁷-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Иххэт сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Намуунзул-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Иххэт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Иххэт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.04-наас 2019.03.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Иххэт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.03.04-ны ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Иххэт сумын төвлөрүүлэн захирагчийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Иххэт сумын Засаг дарга нь Сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, бизнесийн орчинг сайжруулах, эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангаж, мэдлэгт суурилсан эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх. “Хүнээ дэмжиж хамтдаа хөгжих” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Иххэт сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6 байгууллага, ЗГТС 2 нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 6 байгууллага, 2 тусгай сан аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Иххэт сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	5	3			
2						
	Дүн	5	3			

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Иххэт сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Иххэт сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Иххэт сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй байна.

Иххэт сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Иххэт сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин,

дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон.

Иххэт сумын Засаг дарга 2018 оны нийт зардал 2,384,582.5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 47,691.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Иххэт сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 27.1 сая төгрөгийн, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээлтийн сангийн орлого зарлагыг төлөвлөж ИТХ-аар батлуулаагүй, СХС-аас олгосон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавиагүй, зээлийг барагдуулах тодорхой ажил зохион байгуулаагүй, өмнөх аудитын анхааруулга, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1. Ерөнхий боловсролын сургууль: Ажиллагсдын орон тоо баталсан төсвөөс 2-оор илүү ажилласан байна.

Шийдэл: Төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа БСШУСайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлж ажиллагсдын орон тоо, бүтцийг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

2. Эрүүл мэндийн төв: Төсвийн гүйцэтгэлийн тайланд хангамж, бараа материалын зардал 96.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 31.4 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн зарчмыг баримтлан төсвийн төсөөллийг бодитой төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах

Асуудал 2: Балансын данстай холбоотой асуудал

1. **Ерөнхий боловсролын сургууль:** Санхүүгийн тайлангийн тодруулга болон тооцоо нийлсэн актыг тулган шалгахад Татварын албанаас 115.7 мянган төгрөгийн авлага, Чандмань-Илч ХХК-д 7000.2 мянган төгрөг, Хос гэгээн наран ХХК-д 230.5 мянган төгрөг, НДХ-т 287.5 мянган төгрөгийн өглөгийг тус тус тайлагнасан байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллаж авлага, өглөг үүсгэхгүйн тулд төсвийн хуваарилалт, төлөвлөлтийг оновчтой болгох, үүссэн өр төлбөрийг шийдвэрлэхийн тулд холбогдох тооцооллыг бодитой хийх зөвлөмж өгөв.

2. **Цэцэрлэг:** 2018.12.31-ний байдлаар авлага 121979 төгрөгийн, өглөг 222232 төгрөгийн, Татварын хэлтсээс 92960 төгрөгийн авлагын тус тус үлдэгдэлтэй байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн 6.4.8, 39.4.2, 45.2 заалтуудыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

3. **Цэцэрлэг:** Нийгмийн даатгалын тайлангаар 342753,52 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй боловч тооцоо нийлж санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Шийдэл: Нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдэл буруу гарч байгаа тул холбогдох залруулгыг харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад хийлгэж үлдэгдлийг тулгах

4. **Цэцэрлэг:** 2018 оны жилийн эцсээр хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна

Шийдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2 "Хөрөнгө, өр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан

гаргахын өмнө" гэсэн заалтууд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлд заасан заалтыг мөрдөж ажиллах нь зөвлөмж өгөв.

Асуудал 3: Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагааны асуудал

1. **Ерөнхий боловсролын сургууль:** Цалингийн хүснэгт болон төлбөрийн хүсэлт, харилцах дансны хуулгаар 6195.0 мянган төгрөгийн хуримтлалд суутган авсан ба 1-11 дүгээр сард ажилтан бүрээс 15.0 мянган төгрөг, 12 дугаар сард 30.0 мянган төгрөг суутган авсан байна.

Шийдэл: Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1 Ажилтны цалин хөлснөөс зөвхөн дор дурдсан тохиолдолд суутгал хийж болно. 63.1.1. Ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан, 63.1.2. Хууль тогтоомжид заасан бусад тохиолдол гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаж шүүхийн шийдвэр болон холбогдох эрх зүйн актгүйгээр ажиллагсдын цалингаас суутгал суутгахгүй байх зөвлөмж өгсөн.

2. **Ерөнхий боловсролын сургууль:** Сумын ИТХ-ын 2018 оны 12 сарын 16-ны өдрийн 09/10 тоот тогтоолын дагуу 14 нэр төрлийн 7270.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан.

Шийдэл: Улсын төсвийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг актлахдаа Төрийн өмчийн хорооны зөвшөөрлөөр актлах

3. **Соёлын төв:** Төсвийн тухай хууль болон төрийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчин төсвийн хэмнэлтээс 1366,2 мянган төгрөгийг Татварын хэлтэст шилжүүлэн ажиллагсадтай холбогдсон авлага, , 631,0 мянган төгрөгийг "Чандмань -Илч" ХХК-д илүү шилжүүлэн цэвэр, бохир усны авлага үүсгэсэн байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 45.2. "Төсвийн захирагчийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн тул 1997.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Асуудал 4: Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

1. **Соёлын төв:** Жилийн нийт худалдан авалтын 86 хувь буюу 3632.1 мянган төгрөгийн худалдан авалтыг 12 дугаар сард гүйцэтгэсэн байна. Үүнээс 14 хувийг зарцуулсан нь материаллаг нөөцийг нэмэгдүүлсэн байна. 2018 оны эхний 7 сард худалдан авалт хийгээгүй нь жил бүрийн төгсгөлд өндөр дүнгээр худалдан авалт хийж нөөц үүсгэн ажилладаг болох нь нотлогдож байна.

Шийдэл: Бараа материал худалдан авах төлөвлөгөөг баталж худалдан авалтыг гүйцэтгэх, хэрэгцээгүй бараа авах ажиллагааг таслан зогсоох зөвлөмж өгөв.

Асуудал 5: Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

1. **Цэцэрлэг:** Хууль тогтоомжийн дагуу Хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж авч байгаа ажилчдад ХХОАТ гэж 10%-г суутган тэтгэмж дутуу олгосон байна.

Шийдэл: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.1-д "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж"-г албан татвараас чөлөөлөх гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Асуудал 6: Зардлын данстай холбоотой асуудал

- Цэцэрлэг:** Манаач нарт шөнийн цаг бодогддоггүй бөгөөд илүү цагийн хөлсийг байгууллагын хамтын гэрээнд нөхөн амруулаагүй тохиолдолд үндсэн цалинг 1,8 дахин нэмэгдүүлж олгохоор заасан байхад 1,5 дахин нэмэгдүүлж бодсон байна.

Шийдэл: Байгууллагын захиргаа, ҮЭ-н гишүүдийн төлөөллийн хооронд байгуулсан хамтын гэрээний заалтыг мөрдөж ажиллах нь зүйтэй.

- Засаг даргын тамгын газар:** Үйлчлэгч Д.Нарантуяад 200.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон ба 100.0 мянган төгрөгийн цалинг дутуу суутгасан байна.

Шийдэл: Дутуу суутгасан урьдчилгаа цалин 100.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 0 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Үүнээс: Залруулгын ангилал

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
		00	0	0	0	0

Дүн 00 0 0 0 0

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	1	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	0	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан.

Иххэт сумын Засаг даргын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлангийн анхаарал татахуйц бусад чухал асуудал хэсэгт “2011 онд зээл авсан 6 иргэний 17.8 сая төгрөгийн зээлийг шүүхээр шийдвэрлүүлсэн боловч эргэн төлөх үйл явц хангалтгүй, мөн 2012-2015 онд зээл авсан, зээлийн хугацаа нь болсон ч төлөөгүй 32 иргэний 116.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна” гэсэн асуудал тайлант онд хэвээр байгаа бөгөөд шийдвэрлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, ИТХ-аар авч хэлэлцээгүй байна. Мөн 2018 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитаар өгсөн хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй зээл, зээлийн хүүгийн төлбөр дээр нэмж 3.3 сая төгрөгийн алданги тооцох, зээлдэгчдээр зээлийн төлбөрийг хугацаанд нь төлүүлэх гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, насжилт өндөртэй авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Тухайлбал: 2018 оны эцэст шүүхийн шийдвэртэй гэж ангилсан /2011 онд зээл авсан/ 6 иргэний 17.9 сая төгрөгийн, шүүхийн шатанд гэж ангилсан /2012-2014 онд

зээл авсан/ 26 иргэний 86.0 сая төгрөгийн, хэвийн төлөлттэй гэж ангилсан /2017 онд зээл авсан/ 11 иргэний 31.7 сая төгрөгийн, нийт 43 иргэний 135.6 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байна.

Энэ нь ЗГ-ын 2016 оны 153 дугаар тушаалаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 5.2. “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана” 5.3.2. “сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Энэхүү зөрчилд сум хөгжүүлэх сангаас зээл авсан, хугацаандаа төлбөрөө барагдуулаагүй иргэдийн төлбөрийг барагдуулах ажил зохион байгуулах, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын дагуу сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх албан шаардлага бичив.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нөхөн сэргээлтийн сан дансанд байршуулсан хөрөнгийг тайлант хугацааны үр дүн гэж тайлагнасан байна. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниас үйл ажиллагаа явуулсан тухайн жилийн эцэст байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор барьцаанд байршуулсан хөрөнгийг өр төлбөрөөр бүртгэж тайлагнах асуудлыг авч үзэх нь зүйтэй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Иххэт сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 24 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1,888,869.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1,937,397.3 мянган төгрөг буюу 102.5 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1,876,486.5 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл

№	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Орлого	1,888,869.4	1,937,397.3	48,527.9
2	Татварын орлого	61,921.7	62,871.7	950.0
3	Татварын бус орлого	3,338.5	4,964.5	1,626.0
4	Санхүүгийн дэмжлэг	255,614.4	255,614.4	-
5	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	79,490.5	79,490.5	-
6	Тусгай зориулалтын шилжүүлэг	1,488,504.3	1,480,861.2	(7,643.1)
7	Сум хөгжүүлэх сан	-	46,671.0	46,671.0
8	Нөхөн сэргээх сан	-	6,924.0	6,924.0
9	Зарлага	1,888,869.4	1,876,486.5	12,382.9
10	ЗДТГ азар	277,576.0	274,813.2	2,762.8
11	ИТХурал	41,460.1	41,107.0	353.1
12	ЕБСургууль	743,039.7	742,791.7	248.0
13	Цэцэрлэг	252,915.5	252,257.4	658.1
14	Соёлын төв	212,175.8	210,038.5	2,137.3
15	ЭМТөв	282,211.8	277,774.8	4,437.0
16	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	79,490.5	77,703.9	1,786.6

2.11. Шилэн дансны мэдээлэл

Иххэт сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Иххэт сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 100.0 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, гарсан зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

Иххэт сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	3	0			3	0		
2	ТШЗ	14	27.1			14	27.1		
3	ТБӨААН	0	0			0	0		
	Дүн	17	27.1			17	27.1		

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Сая төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Хариуцлага тооцуулах санал								Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	3	0			1	0	2	0	0	0	0	0
2	ТШЗ	14	27.1	2	2.1	0	0	12	25.0	0	0	0	0
3	ТБӨААН												
	Дүн	17	27.1	2	2.1	1	0	14	25.0	0	0	0	0

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Иххэт сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иххэт сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	4	1	0	0	5
2	ТБӨӨААН	0	0	0	0	0
	Дүн	4	1	0	0	5

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Иххэт сумын Засаг дарга нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

3.1. Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлт

3.1.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн орлого, зарлагын төсвийг сумын ИТХ-аас батлаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27.1.7 "Орлого зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" мөн хуулийн 32.2.9 "Тусгай сангийн орлого, зарлагын тооцоо" -г төсвийн төслийн танилцуулгад оруулна гэсэнтэй нийцэхгүй байна.

3.1.2 **Эрсдэл:** төсөв хэтрэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн тухайн жилийн орлого, зарлагын тооцоог хийж ИТХ-аар хэлэлцүүлэн төсөв батлуулах

3.2.1. Илрүүлэлт: Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Тайлант онд нийт 43 иргэдээс 135.6 сая төгрөгийн зээлийн авлагатай бөгөөд “зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл, эргэн төлөлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн” гэсэн судалгаанд тухайн тайлант оны төлбөрийн барагдуулалтыг тусгайлан гаргаж харуулаагүй, нийт төлсөн гэсэн баганд зээл авсан үеэс хойших бүх төлөлтийг харуулсан байна.

Энэ нь 14.3.-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ:

14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх;

14.3.2.журналд бичих;

14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;

14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Зээлийн төлөлт, авлагын дүнг буруу тооцох, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зээл, хүү, алдангийн тооцооллыг хийж мөнгөн хөрөнгө, тооцооны данс болон НББ-ийн журнал хөтөлж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	452,312,473.37	467,660,312.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	65,098,350.00	115,192,275.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	65,098,350.00	115,192,275.00
31210	Төгрөг	65,098,350.00	115,192,275.00
31211	Төрийн сангийн харилцах	65,098,350.00	115,192,275.00
33	АВЛАГА	217,055,868.00	155,691,332.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	597,000.00	1,395,184.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	20,429,365.00	15,204,765.00
33500	Бусад авлага	11,556,024.00	3,670,505.00
33510	Байгууллагаас авах авлага	11,556,024.00	3,670,505.00
33600	Зээлийн авлага	184,473,479.00	135,420,878.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	184,473,479.00	135,420,878.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	184,473,479.00	135,420,878.00
35	БАРАА МАТЕРИАЛ	159,258,255.37	185,876,705.16
35100	Түүхий эд материал	10,089,392.16	8,548,636.16
